



**MONGOLIAN A1 – STANDARD LEVEL – PAPER 1**  
**MONGOL A1 – NIVEAU MOYEN – ÉPREUVE 1**  
**MONGOL A1 – NIVEL MEDIO – PRUEBA 1**

Monday 22 May 2006 (morning)  
Lundi 22 mai 2006 (matin)  
Lunes 22 de mayo de 2006 (mañana)

1 hour 30 minutes / 1 heure 30 minutes / 1 hora 30 minutos

---

**INSTRUCTIONS TO CANDIDATES**

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a commentary on one passage only. It is not compulsory for you to respond directly to the guiding questions provided. However, you may use them if you wish.

**INSTRUCTIONS DESTINÉES AUX CANDIDATS**

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez un commentaire sur un seul des passages. Le commentaire ne doit pas nécessairement répondre aux questions d'orientation fournies. Vous pouvez toutefois les utiliser si vous le désirez.

**INSTRUCCIONES PARA LOS ALUMNOS**

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un comentario sobre un solo fragmento. No es obligatorio responder directamente a las preguntas que se ofrecen a modo de guía. Sin embargo, puede usarlas si lo desea.

Доорх хоёр зохиолын хэсгийг уншаад, аль нэгийг сонгон, тайлбарлаж бич.  
Хэрэв шаардлагатай гэж үзвэл зохиолын төгсгөлд буй удирдамж асуултын дагуу бичиж болно.

1. (a)

5 ...Бадам зовиуртай зүүднээсээ арай гэж сэрэхэд гэрийн хоймор сарны гэрэл тусаж, хажууд нь эр нөхөр нь тайвуухан хурхирна. Бадам Батын царайг эмээнгүй хараад өдөр Дэвээ авгайн бэр амаржиж охин гаргахад "Шинэ засгийн үед төрсөн энэ азтай бүсгүй хүүхэд богтлогдохын зовлон үзэхгүй биз ээ" гэж бодож байснаа санав.

10 Энэ үест Догсом замын хувцсаа хөнгөлөөд, Бадам ирж юун магад хэмээн хүлээх зуур түүний оруулж тавьсан домботой хөрчихсөн цайнаас аягандаа хийн залгилж байв. Тэгээд төлөөний түшмэл "Яагаад ч юм бэ, цаг тайван болж байна даа" гэж бодон санаа алдлаа. Гараа дэрлэн хэвтэхэд 10 бүсгүйн зөөлөн царай цээжинд нь дурайж хол явахдаа "тэгж ярина, ингэж хөөрнө" хэмээн санавч түвэгтэй ажилдаа шимтэн мартагнана. Гэсэн ч хонхны оосроос сэм сэмхэн дугтрах шиг газрын холоос Бадам чамайгаа үгүйлэн дурсаж явна даа хэмээн сэтгэлээ сэргээж байсан нь саяхан мэт ажээ. Гэтэл одоо хажууханд нь ирчихээд л байж байна. Түүнийг ийнхүү 15 бодоход, эмээнгүй боловч элэгсэгээр, бас дураараадуухан инээвхийлсээр ороод ирдэг нь санагдав.

Бадам өглөө хүйтэн цай өрөмтөн хоносон байдаг домбоо авахаар Догсомын байшинд орвол хүлээсэн хүн нь ирчихсэн, хаашаа ч яваагүй юм шиг дээлийнхээ ханцуйг сугалдаргалаад ширээ тохойлдон сууж нэгэн 20 зүйлийг хөнгөхөн татлан бичиж байв.

Амар мэндээ хэрхэн сольсноо ч Бадам мэдсэнгүй, амнаас нь ямар ч утга холбоогүй мэт авч хайр сэтгэлийн аясаар үг урсан гарна. Түүний цээжинд хөөр баяр оволзож хорвоод өөр шиг нь жаргалтай хүн байхгүй мэт санагдав.

25 Догсом баахан аяншиж ядарсан царайтай авч нөгөө аргил сайхан хоолой нь хэвээр, угсал зөөлнөөр харах нь бүсгүйг нэг талаар тайвшруулж, нөгөө талаар догдлуулна.

- Бадам аа, бичиг мэдэх үү? гэж огт санамсаргүй асуухад нь Бадам - Үгүй ээ гэж сулхан хэлээд нүүрээ улайлгав.

30 - Би ингэж бичсэн юм, сонсооч гээд Догсом өмнөх цаасаа дэлгэхэд Бадам домботойгоо барьсан хэвээр цомцойн суулаа.

Хүүхэн хонгорын зөөлөн дуу  
Хүдэр цээжинд хоногшоод байна

35 Хүлгийн нурууг амраах цаг  
Хөвч хангайд минь ирээ юу даа.

Эрэвгэр нүдний уяхан харц  
Энгэр цээжийг нэвтлээд байна.

Энэ биеийг амраах цаг  
Эх нутагт минь ирээ юү дээ.

40 Түвшин шударга бүсгүйн царай  
Төөрсөн зүүднээс салахаа болилоо

Төрийн нуруу төвшрөх цаг  
Түмэн олонд минь ирээ юу даа.

- 45 Догсом шүлгээ уншаад хэсэг дуугүй сууснаа өөрийг чинь бодоод үүнийг бичлээ. Санаанд чинь хүрэв үү? гэж асуув. Бадам баярлахын сацуу эмээх сэтгэл төрж наалинхай байдлаар хөмсгөө хөдөлгөн бодолхийлснээ:  
- Би чинь бичиг ч мэдэхгүй, харанхуй цээжтэй хүн шүү гэв.  
- Бичиг сурч бололгүй яах вэ гээд Догсом хуудас цаас дэлгэн “А Э И О Ө У Ү” үсгийг нямбай, томоор бичин дуудаж өгөөд үүнийг хэдэн удаа
- 50 дууриалган бичиж ирээд надад үзүүлээрэй гэв.  
Тэгснээ богцоо уудалж шовх үзүүртэй харандаа гарган өгөв. Бадам зүрхнийхээ түгшихийг баяртайгаар мэдрэн, эв дүйгүйхэн дууриалган бичихийг оролдоход Догсом ойртон суугаад,  
- Ингэж бич гэж халуу даасан алгатай том гараараа савх шиг бяцхан гарыг
- 55 нь атган, үсгийг дууриалган татахад гараар нь дамжин бүхий л бие нь бадайрч нурууг нь даган жирвэсхийгээд булбарай цогцсыг нь эмзэглүүлэн замхрав. Олон хоног уулзаагүй нь тэднийг ийнхүү санамсаргүй үг солин улам дотно болгожээ.  
Үүнээс хойш Бадамын сэтгэлд үе үе айдас төрж бидний ярилцсан үг үнэн
- 60 болов уу гэж эргэлзэн, түүнтэй дахин дахин дайралдах юмсан гэж санавч басхүү нүүр тулгарахаас эмээж, цас дарсан уулсын тэргүүнийг ширтэн зогсохдоо түмэн сайхныг мөрөөднө. Гэвч бүтэхгүй юмыг мөрөөдвөл сэтгэлийн тамд унах тул төдөлгүй уйтгарладаг байлаа.  
Бараа бараагаа харалцавч үг солин удтал суух эрхгүй нь хоёр
- 65 залуугийн бие биенээ хүсэмжлэх сэтгэлийг дэврээнэ.

*М.Чойжил “Амрагийн дууль”, 1994*

- Зохиолын энэ хэсэгт Бадам, Догсом нарын дүрийг хэрхэн дүрсэлсэн бэ?
- Зохиолд 1920-иод оны нийгмийн онцлогийг хэрхэн тусгасан бэ?
- Зохиолын энэ хэсэгт хайр сэтгэлийн тухай хэрхэн дүрсэлсэн бэ?
- Зохиолч уншигчийн анхаарал, сонирхлыг татахын тулд уран дүрслэлийн ямар арга хэрэглэснийг тайлбарла.

1. (b)

- Дунд оршгүй мэлтэлзэх саамын хувин тохойвчилж  
Дуучин цээл хоолойгоор үнээн зэлнээ өөвлөнхөн  
Дулаан эсгий өргөө шиг дуулим талын өвөр дээр  
Дун цагаан үүрийг хэний хэн авчирлаа
- 5 Дурлам энхрий сэтгэлтэй миний л амраг чи дээ.
- Хорол тоонын өрхийг хунгийн даль шиг дэрвүүлж  
Хонгор шархан дөлтэй галаа хэн асаалаа  
Ховор тансаг амттанаа хоёр гардан барьж  
Хол ойрын түмэнд нэрээ хэн гаргалаа
- 10 Хослон жаргах итгэлтэй миний л амраг чи дээ.
- Яргуй задрах хаврын урьхан хонгор өдрүүдээр  
Янагийн цагаан сэтгэлд мөрөөдөл хэн авчирлаа  
Ялгуун сарны гэрлээр зүүдэн дунд ч тормойж  
Ялдам ханийн аашаар зүрхэнд хэн мишээлээ
- 15 Ямагт наддаа заяасан миний л амраг чи дээ.
- Ижийн сайхан хорвоогийн хоргой эрээн амьдралыг  
Ижилсэнхэн туулья гэж гараа хэн өглөө  
Инээх уйлах хоёры нь эцгийн ёсоор хувааж  
Итгэлээ хожим даатгах үрийг хэн хайрлалаа
- 20 Ижилдэн жаргах ерөөлтэй миний л амраг чи дээ.

*Д.Цоодол “Миний л амраг чи дээ”, 1969*

- Энэ шүлгийн агуулга, утга санаа юу вэ?
  - Зохиолч адилтгал, зүйрлэлийн арга, монголчуудын бэлгэдэх сэтгэлгээний онцлогийг хэрхэн дүрсэлсэн бэ?
  - Зохиогч толгой холбох, сүүл холбох аргыг хэрхэн хэрэглэснийг тайлбарла.
  - Зохиолыг уншаад төрсөн сэтгэгдлээ бич.
-